

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
2022 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ  
ИННОВАЦ, ЦАХИМ БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ  
12 ДУГААР САРЫН 13-НЫ ӨДӨР /МЯГМАР ГАРАГ/-ИЙН  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН  
ТОВЬЁГ**

№	Хэлэлцсэн асуудал	Хуудасны дугаар
1.	Хуралдааны товч тэмдэглэл:	1-2
2.	Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	3-21
	<b>1. Монгол Улс, Дэлхийн банкны Олон улсын хөгжлийн ассоциаци хоорондын “Ухаалаг засаг-2 төсөл”-ийн Зээлийн хэлэлцээрийн төсөл /Монгол Улсын Засгийн газраас 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдөр ирүүлсэн, зөвшилцөх, санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлнэ/</b>	3-21

**Монгол Улсын Их Хурлын 2022 оны намрын ээлжит чуулганы  
Инновац, цахим бодлогын байнгын хорооны 12 дугаар сарын 13-ны өдөр  
/Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Инновац, цахим бодлогын байнгын хорооны дарга Э.Батшугар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 11 гишүүнээс 7 гишүүн хүрэлцэн ирж, 63.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 20 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Эмнэлгийн чөлөөтэй: Ч.Ундрам;  
Тасалсан: Э.Бат-Амгалан.

**Нэг.Монгол Улс, Дэлхийн банкны Олон улсын хөгжлийн ассоциаци хоорондын “Ухаалаг засаг-2 төсөл”-ийн Зээлийн хэлэлцээрийн төсөл /Монгол Улсын Засгийн газраас 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдөр ирүүлсэн, зөвшилцөх, санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлнэ/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Засгийн газрын гишүүн, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн дарга Ч.Золбаяр, мөн яамны Цахим хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Билэгдэмбэрэл, Төрийн захиргаа, удирдлагын газрын дарга Б.Батцэцэг, Сангийн яамны Санхүү, бодлогын газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга Д.Одонтуяа, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Мэдээллийн технологийн хэлтсийн дарга Ж.Тамир нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Инновац, цахим бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх П.Батбаатар, референт П.Болорцэцэг нар байлцав.

Зөвшилцөх тухай асуудлын талаар Засгийн газрын гишүүн, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг, Ц.Идэрбат, Ж.Чинбүрэн, Ц.Сэргэлэн нарын тавьсан асуултад Засгийн газрын гишүүн, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал, Сангийн яамны Санхүү, бодлогын газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга Д.Одонтуяа, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Мэдээллийн технологийн хэлтсийн дарга Ж.Тамир нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Э.Батшугар үг хэлэв.

**Э.Батшугар:** Монгол Улс, Дэлхийн банкны Олон улсын хөгжлийн ассоциаци хоорондын “Ухаалаг засаг-2 төсөл”-ийн зээлийн хэлэлцээрийн төслийг зөвшилцөх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хуралт явуулья.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 2  
Бүгд: 9  
77.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сэргэлэн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 15 цаг 05 минутад хэлэлцэж дуусав.*

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 46 минут үргэлжилж, 11 гишүүнээс 9 гишүүн хүрэлцэн ирж, 81.8 хувийн ирцтэйгээр 15 цаг 06 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**

ИННОВАЦ, ЦАХИМ БОДЛОГЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ  
ДАРГА

Э.БАТШУГАР

**Тэмдэглэл хөтөлсөн:**

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ  
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
2022 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ  
ИННОВАЦ, ЦАХИМ БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ  
12 ДУГААР САРЫН 13-НЫ ӨДӨР /МЯГМАР ГАРАГ/-ИЙН  
ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ  
ТЭМДЭГЛЭЛ**

**Э.Батшугар:** Байнгын хорооны эрхийн гишүүд энэ өдрийн амгаланг айлтгая.

Байнгын хорооны гишүүд олонх хүрэлцэн ирсэн тул Инновац, цахим бодлогын байнгын хорооны 2022 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 11.6-д заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя.

Э.Батшугар 28 дугаар тойрог, Н.Ганибал 12 дугаар тойрог, Х.Ганхуяг 26 дугаар тойрог, Ц.Идэрбат 18 дугаар тойрог, Ц.Сэргэлэн 7 дугаар тойрог, Н.Учрал 28 дугаар тойрог, Ж.Чинбүрэн 23 дугаар тойрог.

Байнгын хорооны хуралдааны ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны хуралдааны хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Монгол Улс, Дэлхийн банкны Олон улсын хөгжлийн ассоциаци хоорондын “Ухаалаг Засаг-2 төсөл”-ийн Зээлийн хэлэлцээрийн төсөл.

Монгол Улсын Засгийн газраас 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдөр ирүүлсэн. Зөвшилцөх. Санал, дүгнэлтийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлнэ.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Хэлэлцэх асуудалд оръё.

Монгол Улс, Дэлхийн банкны Олон улсын хөгжлийн ассоциаци хоорондын “Ухаалаг Засаг-2 төсөл”-ийн Зээлийн хэлэлцээрийн төслийг зөвшилцөх асуудлыг хэлэлцье.

Монгол Улс, Дэлхийн Банкны Олон улсын хөгжлийн ассоциаци хоорондын “Ухаалаг Засаг-2 төсөл”-ийн Зээлийн хэлэлцээрийн төслийн талаарх танилцуулгыг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Ням-Осорын Учрал таницуулна.

**Н.Учрал:** Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газар, Дэлхийн банкны Олон улсын хөгжлийн ассоциацитай хамтран хэрэгжүүлэх “Ухаалаг засаг-2 төсөл”-ийн бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

Нэгдсэн Үндэстний Байгууллагаас гаргадаг иргэдийн цахим оролцооны индексээр Монгол Улс 2022 оны байдлаар 74 дүгээр байрт, Дижитал өрсөлдөх чадварын индексээр 62 дугаар байрт, Олон улсын цахилгаан холбооны байгууллагаас гаргадаг Киберийн аюулгүй байдлын индексээр 120 дугаар байрт тус тус орсон байгаа нь манай улсын хувьд мэдээллийн технологийн дэвшлийг ашиглаж авлигыг бууруулах, эдийн засгийн өсөлтийг дэмжих, төрийн бүтээмжийг нэмэгдүүлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх шаардлагатай байгааг харуулж байна.

“Ухаалаг засаг-2 төсөл” нь дараах Монгол Улсын урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдаж байна.

Нэг.Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын Зорилт 5.3-т хүний хөгжлийг дэмжсэн үр дүн, үр нөлөөтэй цахим засаглалыг төлөвшүүлнэ гэж.

Хоёр.Зорилт 7.5-д төр, иргэн, хувийн хэвшлийн мэдээллийн бүрэн бүтэн, нууцлагдсан, хүртээмжтэй байдлыг баталгаажуулж, өрсөлдөх чадварыг бий болгоно гэж.

Гурав.Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.1-д Цахим хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлт, удирдлагаар хангаж, төрийн үйлчилгээг хариуцлагатай, хүртээмжтэй хүргэх нөхцөлийг бүрдүүлж, иргэдийн цаг хугацаа, зардлыг хэмнэнэ гэж.

Дөрөв.“Шинэ сэргэлтийн бодлого”-ын Төрийн бүтээмжийн сэргэлтийн 6.1-д төрөөс үзүүлэх үйлчилгээг цахимжуулж, төрийн хүнд суртлыг бууруулна гэж тус тус заасан.

Тус төслийн нэгдүгээр үе шат болох “Ухаалаг засаг-1 төсөл”-ийг хэрэгжүүлсэн бөгөөд төрийн үйлчилгээний нэгдсэн платформ системд төрийн 68 байгууллагын 789 үйлчилгээ, хөдөө орон нутагт 1284 үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлж, ухаалаг газрын харилцааны системийг идэвхжүүлэн, 103 мянга гаруй иргэнд үйлчилгээг цахимаар хүргүүлээ.

Мөн улсын бүртгэлийн байгууллагаас 357 мянга 705 иргэнд тоон гарын үсгийн гэрчилгээг иргэний үнэмлэхэд нь суулгаж олгосон байна.

Цаашид төрийн цахим үйлчилгээний суурь зөөлөн дэд бүтэц бий болгох, үндсэн болон дэмжих системийг өргөтгөн хөгжүүлж, бүх шатны төрийн байгууллагуудыг холбох дундын үүлэн шийдлийг нэвтрүүлж, үндэсний дата төвийн хүчин чадлыг нэмэгдүүлж, тоон гарын үсгийн дэд бүтцийг иж бүрнээр нь шинэчлэн хэрэглээг нэмэгдүүлж, кибер аюулгүй байдлыг хангах, төрийн байгууллагын цахим

албан бичиг солилцох, хурдасгах, дижитал эдийн засгийн өсөлтийг дэмжих зорилгоор “Ухаалаг засаг-2 төсөл”-ийг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

Энэхүү “Ухаалаг засаг-2 төсөл”-ийн зээлийн хэлэлцээрийг 2022 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр хийж, тус банкны Захирлуудын зөвлөл 06 дугаар сарын 06-ны өдөр баталсан.

Дэлхийн банкны Олон улсын хөгжлийн ассоциациас авч ашиглах 29.5 сая зээлжих тусгай эрхийн эх үүсвэр нь жилийн тогтмол 2 хувийн хүүтэй. Эхний 5 жил үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөж, 30 жилийн хугацаанд эргэн төлөх нөхцөлтэй бөгөөд зээлийн хэлэлцээрийг Улсын Их Хурлаас соёрхон батлуулах шаардлагатай байна.

Иймд зээлийн хэлэлцээрт гарын үсэг зурах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү. Баярлалаа.

**Э.Батшугар:** Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Н.Учрал Цахим хөгжил, харилцаа холбооны сайд, Ч.Золбаяр Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн дарга, Б.Билэгдэмбэрэл Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Цахим хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, Б.Батцэцэг Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Төрийн захиргаа, удирдлагын газрын дарга, Д.Одонтуяа Сангийн яамны Санхүү, бодлогын газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга, Ж.Тамир Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Мэдээллийн технологийн хэлтсийн дарга.

Зээлийн хэлэлцээрийн төсөлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд нэрээ өгнө үү? Х.Ганхуяг гишүүнээр тасалъя. Х.Ганхуяг гишүүний микрофоныг нээе.

**Х.Ганхуяг:** Энэ өдрийн мэндийг хүргэе.

**Smart Government II** төслийн энэ холбогдох Дэлхийн банкны хүмүүстэй өнгөрсөн долоо хоногт бас уулзалт хийсэн.

Тэгээд энэ ажлын цар хүрээнд зөвшөөрлийн платформыг энэ санхүүжилтээс бас хийхээр туссан байгаа. Нийтдээ 362 зөвшөөрлийг 80 гаруй эрх бүхий этгээд олгодог болох юм.

Тэгээд үүнийг цахим нэгдсэн платформ болгох, тэгээд ингээд зөвшөөрөл хүсэхээс авхуулаад зөвшөөрөл явагдаж байгаа процессыг нь ил тод нээлттэй цахимаар хардаг болгох. Мөн олгодог болгох гэсэн. Бүгдийг нь цахимаар шилжүүлэх. Мөн бүх яам, Тамгын газар, агентлаг бүгдийг нь яг энэ цахим нэг платформтой болох дээр энэ санхүүжилт зарцуулагдах байгаа юм.

Өмнөх **Smart Government I** төсөл нь маш амжилттай болсон. Одоо **e-mongolia** төсөл гээд нийтдээ мянга гаруй төрийн үйлчилгээг нэгтгээд явж байгаа.

Энэ дээр ганц санал байгаа юм. Н.Учрал сайд байгаа болохоор бас хэлчихье гэж бодсон юм. Ямар санал байна вэ гэхээр бид нар одоо ингээд цахим платформ, ингээд цахим шилжилт гээд олон асуудлуудыг ярьж байдаг.

Энэ бүхнийг яг амжилттай хэрэгжүүлээд амьдралд нэвтрүүлэе гэхээр яг нөгөө **“digital literacy”** гэж ярих уу? Одоо иргэд, залуучууд, хүүхдүүдийн цахим мэдлэгийг дээшлүүлэх тал дээр анхаарч ажиллахгүй бол бас боломгүй юм билээ.

Одоо нөгөө Эстонийн туршлага байна л даа. Яг цахим шилжилтийг хийсэн туршлага нь юу байна гэхээр тэр цахим боловсролыг олгох асуудал нэлээн анхаарал тавьж явсан. Бүх өрхүүддээ тухайлбал компьютер олгохоос авхуулаад ерөнхий боловсролын сургууль дээр нь тэр цахимын хөтөлбөрийг нь бүгдийг нь шинэчилсэн байдаг.

Тэгээд үүнийг би бас Н.Учрал сайдыг цаашдаа анхаараад явчхаасай гэж бодож байна.

Өнөөдөр тухайлбал одоо төрийн сургуулиудын дийлэнх нь цахим лабораторигүй байна. Одоо ашиглаж байгаа хөтөлбөр нь 15-аас 20 жилийн өмнө бичигдсэн хөтөлбөрийг ашиглаад явж байгаа. Гэтэл цахим ертөнц, нөгөө хиймэл оюун ухаан яриад. Одоо хүртэл энэ ерөнхий боловсролын сургуулиудад байхгүй байгаа. Хөтөлбөрт нь.

Тэгэхээр энэ тал дээр анхаарч үзээч ээ гэдэг нэг асуудлыг яримаар байна.

Хоёрдугаарт, энэ зээлтэй холбоотойгоор манай улс буурай хөгжилтэй орноос хөгжиж буй орон гэдэг жагсаалт руу шилжсэн байгаа. Энэ зээл нь болохоор нэн хөнгөлөлтэй буюу одоо буурай орнуудад олгодог нөхцөлөөр олгож байгаа. Зээлийн ангилалаараа бас ийм онц ач холбогдолтой байгаа юм.

Тэгэхээр цаашдаа энэ авлигалыг бууруулах, Засгийн газрын нээлт, ил тод байдалтайгаар үйл ажиллагаагаа явуулах, иргэдэд энэ үйлчилгээг түргэн шуурхай хүргэх зэрэг ач холбогдолтойгоороо онцлогтой юм.

Тэгэхээр гишүүд та бүхнээс бас үүнийг дэмжээд өгөөч ээ гэж хүссэн юм. Баярлалаа.

**Э.Батшугар:** Н.Учрал сайдын микрофон нээе.

**Н.Учрал:** Х.Ганхуяг гишүүн ажлын хэсгийг нь ахалж батлуулсан Зөвшөөрлийн хуулийг Улсын Их Хурал баталсан.

Тэгэхээр Зөвшөөрлийн хууль бол авлигагүй, ил тод, яг иргэдийн хүсээд байгаа нийгмийг бүтээх эрх зүйн үндсийг тогтоож өгсөн гэж энэ хуулийн ач холбогдлыг үнэлж байгаа.

Одоо энэ хуулийг амилуулах ажил бол Монгол Улсын Засгийн газрын ажил. Тийм ч учраас энэ Дэлхийн банкны “Ухаалаг засаг-2 төсөл”-ийн хүрээнд тусгай зөвшөөрлийн нэгдсэн системийг хөгжүүлэх, мөн худалдан авах ажиллагааны цахим порталыг шинэчлэх, энэ интеграцыг хийх асуудлыг энэ “Ухаалаг засаг-2”-ын хүрээнд хийнэ.

Өнгөрсөн хугацаанд Улаанбаатар хот бол өөрсдөө “**UB online business**” гэж платформ үүсгээд одоо өдөр тутам иргэдийн авдаг зөвшөөрлүүдийг цахимжуулсан.

Гэхдээ бид тухайн тусгай зөвшөөрлийг авахад материалыг нь цахимаар авдаг болсныгоо одоо зөвшөөрлийг цахимжуулсан гэж нэрлэх нь зохимжтой биш. Яг хиймэл оюун ухаан ажиллаад тухайн зөвшөөрөл ямар нэгэн хүнтэй холбоогүйгээр шууд шийдэгддэг болох юм бол нөгөө авлигал, хээл хахууль гэдэг зүйл чинь арилах ёстой юм.

Тийм ч учраас бид энэ олон системүүдийг нэгтгэх ажлыг эхлүүлсэн. Эдийн засгийн хөгжлийн яам, Цахим хөгжил, харилцаа холбооны яам хамтраад ажлын хэсэг байгуулаад ажиллаж байна.

Эдийн засгийн яам, Сангийн яаман дээр **lisence.gov.mn** гээд нийт тусгай зөвшөөрлүүдийг цахимжуулах ажлыг эхлүүлээд явж байсан хэдий ч бусад тэр зөвшөөрлийг хийчихсэн байгаа яамдтайгаа уялдахгүй байсан.

Тийм учраас Эдийн засгийн сайд, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын хамтарсан тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг яамдаас олгогддог тусгай зөвшөөрлүүдийг Улаанбаатар хотоос олгож байгаа тусгай зөвшөөрлүүдийг бүгдийг нь нэгтгэсэн ийм **e-business** гэдэг нэгдсэн платформыг үүсгээд эхний prototype хэлбэрийн танилцуулга бэлдсэн.

Ингээд одоо үүнийг hardware талд нь хөгжүүлэх, кибер аюулгүй байдлын талаас нь хангах, тэр мэдээллийг нэгтгэж хадгалах, хамгаалахтай холбоотой төсөв, санхүүгийн асуудлуудыг нь шийдвэрлүүлэхээр “Ухаалаг засаг-2”-ын арга хэмжээний төлөвлөгөөн дотор тусгасан гэдгийг хэлмээр байна.

Үүн дээр Улсын Их Хурлын гишүүд маань дэмжиж ажиллаж байгаад баяртай байгаа. Цаашдаа бид энэ Зөвшөөрлийн хуулийн дагуу 1600 гаруй байсан зөвшөөрлийг одоо бараг 370-д хүргэсэн энэ хуулийг амилуулах ажил нь манай Цахим хөгжил, харилцаа холбооны яам, мэргэжлийн яамны зүгээс технологийн талаас нь дэмжлэг үзүүлж ажиллана гэдгийг хэлмээр байна.

Өнөөдөр нийгэмд үүсээд байгаа уур бухимдал, энэ болгон иргэд өөрсдөө хяналтаа тавья, ил тод болж өгөөч, энэ нууц гэдэг нэрийн доор олон гэрээ хэлцлийг нууцалдаг байдлаа ил тод болгооч. Хүнээс хамааралтай биш, технологи нь шийддэг нийгмийг бүтээж өгөөч ээ л гэж иргэд хүсэж байгаа юм.

Түүнээс биш одоо нөгөө хулгай хийх боломж нь байгаад байх юм бол цаашдаа энэ хулгай нүүрлэсээр л байна.

Тийм учраас хэн нэгнийг сольсноор биш, технологи суурьтай болгож чадах юм бол өнөөдөр энэ нүүрсэн дээр үүсээд байгаа асуудал ч гэсэн тэр худалдах, борлуулах, тээвэрлэх бүх түвшин автоматжих ёстой.

Цаашлаад цахимаараа гэрээгээ хийдэг болоод. Энэ нь гааль, татварын нэгдсэн системтэйгээ холбогдох ёстой гэдэг ийм зарчмыг барьж байгаа учраас Засгийн газрын зүгээс энэ ондоо багтаагаад 01 дүгээр сарын 01-нээс энэ гэрээ борлуулах, тээвэрлэж байгаа, худалдаж байгаа бүх процедурыг автоматжуулна.

Ингээд цахимаар цаашдаа арилжаа хийх бололцоотой болоод эхлэх юм бол хэн нэгэн үүнд нөлөөлөхгүй болох л ийм нөхцөлийг бүрдүүлэхийн төлөө бас анхаарч ажиллаж байна.

**Э.Батшугар:** Ц.Идэрбат гишүүний микрофоныг нээе.

**Ц.Идэрбат:** Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе.

Энэ зээлтэй холбоотой асуудлаар дэмжиж байгаа. Яагаад гэвэл энэ зээл бас үр дүнгээ, одоо бидний зорьж байгаа олон зорилгод чиглэгдэж үр дүнгээ өгнө гэж харж байгаа.

Би цаг үеийн нөхцөл байдалтай холбогдуулаад бас нэг асуух асуулт байсан. Сая ерөнхийдөө сайд хариуллаа.

Энэ Монгол Улсын хил, гааль дээр энэ цахим шилжилтийн асуудал ер нь ямар түвшинд явдаг юм бол? Өнөөдөр бид хэдий хэр нүүрс алдсанаа ч мэдэхгүй, хэдий хэр нь нүүрс гаргасан ч одоо бас яг одоо ийм тоо гэж хэлэхэд хэцүү. Хүн болгон дуртай, дуртай тоогоо хэлдэг. Тэрнээс болоод янз янзын сөрөг үр дагаврууд гардаг. Ийм л байдалтай болчихоод байгаа юм.

Тэгэхээр одоо байгаа энэ хил гааль дээр байгаа цахим шилжилт гэдэг зүйл ийм тэг түвшинд байгаа юм уу? Эсвэл байгаа юмыг ашиглахгүйгээс болоод өнөөдрийн нөхцөл байдал үүсэв үү?

Ер нь цаашдаа та бас хоёр хоногийн өмнө энэ уул уурхайнхантай уулзаж энэ хил, гаалийн цахим шилжилтийн асуудлаар бас тодорхой зүйлүүдийг хийнэ, хэрэгжүүлнэ гэж ярьсан. Энэ талаар тодорхой мэдээлэл өгөөч ээ гэж нэгдүгээрт хүсэж байгаа юм.



Хоёрдугаарт, сая танилцуулга дээрээс бид бүхэн уншиж байна. Олон улсын цахилгаан холбооны байгууллагаас кивер аюулгүй байдлын индексээр 120 дугаарт орж байгаа гэдэг маань нэлээн чамлалттай үзүүлэлт. Сүүлийн гурав, дөрвөн жилийн хугацаанд бид цахим шилжилт, энэ Хувь хүний мэдээллийг хамгаалах, Нууцын тухай хууль, Кибер аюулгүй байдлын тухай хууль гээд ингээд яриад байдаг. Тэгээд энэ маань дэлхийд 120-д орж байна гэдэг бол маш эрсдэлтэй ийм л орчин нөхцөл бид байгаа юм байна гэж харж байгаа юм.

Тэгэхээр ер нь цаашдаа энэ Киберийн аюулгүй байдлын тухай хууль хэрэгжээд энэ чинь одоо бараг 4, 5 сар, 6 сар болох гэж байна. Цаашдаа энэ киберийн аюулгүй байдлыг бид энэ 120 биш илүү ахисан түвшинд хүргэхийн тулд ямар дэмжлэг хэрэгтэй байгаа гэж ингэж үзэж байгаа вэ? Энэ зээлийг авснаар энэ киберийн аюулгүй байдлын өнөөдрийн байгаа түвшин ер нь хэдий хэрээр ахина гэж үзэж байгаа юм бэ гэсэн хоёр асуулт байна.

**Э.Батшугар:** Н.Учрал сайдын микрофоныг нээе.

**Н.Учрал:** Ийм хулгай хийх боломж хулгайчийг төрүүлээд байна. Боломжийг уг үндсээр нь тасдахгүй бол өнөөдөр энэ нүүрсний хулгайтай холбогдсон нөхдүүдэд хуулийн хариуцлага хүлээлгэлээ гээд “А”-г “Б”-гээр солилоо гээд дараа нь дахиад л нөгөө нөхөр хулгай л хийнэ шүү дээ.

Тийм учраас үүнийг уг үндсээр нь устгана гэдэг бол зайлшгүй технологийн дэвшлийг ашиглахаас өөр арга зам байхгүй.

Тийм учраас харилцаа холбоо, мэдээлэл технологийн салбарын сайдын хувиар хувийн хэвшлийнхээ захирлуудад бас ил захидал илгээсэн. Тэгээд үүн дээр та бүхэнд сайн шийдлүүд байх юм бол хамтарч ажиллая л гэж байгаа юм. Түүнээс төр бүгдийг хийдэг гээд одоо хувийнхыгаа хийгээд хэрэгжүүлээд туршаад амжилтад хүрчихсэн системүүдийг булааж аваад хийсээр л өнөөдрийг хүрчихсэн байхгүй юу.

Тэгэхээр бид хийчихсэн зүйлийг дахиад хийх шаардлага байхгүй. Харин хамтарч ажиллах ёстой. Хувийн хэвشلүүд, иргэд, ард түмэн өөрөө хяналтаа тавих ёстой шүү дээ. Энд бирж дээр нь ч гэсэн.

Тийм учраас энэ цахим бирж бол өөрөө энэ нүүрсний худалдаан дээр 24 цаг гэрэл асаах ёстой. Ер нь ийм харанхуй бүүдгэр орчинд л хулгай явагдаад байна шүү дээ. Нүүрсний худалдаа нууц учраас л өнөөдөр энэ байдал ингэтлээ даамжирсан.

Тэгэхээр өнгөрсөн хугацаанд бид Сангийн яамтай, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамтай хамтарч ажиллалаа. Холбогдох мэргэжилтнүүдээс нь санал бодлыг нь сонслоо. Экспертүүдийн үгийг сонслоо. Тэгээд хувийн хэвшил бол өөрсдөө биржийн үйл ажиллагааг технологид суурилоод хийж байна. Бид

блокчэйн дээр бүртгэчихье. Хэн нэгэн хөндөж чадахгүй гээд сайн санаачилга гаргаж байгаа шийдлүүдийг хүлээж авч уулзсан.

Тэгэхээр өнөөдөр Сангийн яамны Гааль, татвар, санхүүгийн мэдээлэл, технологийн төвийнхөн энэ ондоо багтаагаад яг энэ нүүрсний борлуулж байгаа компани нь тээвэрлэж байгаа гэрээ, нөгөө худалдах, худалдан авах гэрээнүүд гээд энэ бүх зүйлүүдийг нь цахим дээр хийх бололцоог нь бүрдүүлчихэж. Автоматжуулаад.

Үүнийг нь бид блокчэйн дээр бүртгэх ёстой. Хэн нэгэн хөндөхгүй байдлаар. Ингээд эхлэх юм бол нөгөө боомт дээр нүүрсийг тээвэрлээд явж байгаа нүүрс нь тэр гаалийн шинжилгээний лаборатори дээр дүгнэлтийг нь гаргахад гэрээнээсээ зөрж байгаа хэсгийг нь хиймэл оюун ухаан ашиглаад л үүнийг нь таньдаг байх ёстой.

Тэгээд нүүрсний арилжаа 100 хувь цахим дээр явагдах ёстой. Хувийн маш олон технологид суурилсан биржүүд байна шүү дээ. Тэгээд энэ нь цахим дээр явагдах ёстой. Тэгээд эхлэх юм бол заавал тэнд тийм таньдаг хүн байна уу, ах дүү, амраг садан дамжуулдаг ийм байдал байхгүй болно шүү дээ. Ямар нэгэн технологитой хүн бол ямар ч хэрүүл уруул хийдэггүй шүү дээ.

Өнөөдөр элсэлтийн ерөнхий шалгалтыг харъя, төрийн албаны шалгалтыг харъя. Цаг тавиад л хугацаандаа шалгалтаа өгөөд л дуусдаг. Хэн ч хэнийг таньдаг тал хайж явж байгаа юм байхгүй шүү дээ.

Тэгэхээр энэ болгоныг бид цахим дээр хийх ёстой гэдэг утгаар явж байгаа.

Тэгэхээр Засгийн газрын зүгээс энэ ондоо багтаагаад энэ нүүрстэй холбоотой бүх гэрээнүүдийг нь цахимжуулж байгаа. Дээрээс нь Засгийн газрын зүгээс жишээ нь “Эрдэнэс Тавантолгой”-той холбоотой бүх гэрээнүүдийг нь ил тод болгож байгаа. Үүнийг нь цаашдаа бүх гэрээнүүд нь цахимжчихна. Тэгээд нүүрсний арилжаа цахим дээр явагдаад эхэлчихээрээ гаднаас ч нүүрс авмаар байна гэх юм бол өөрөө хүсэлтээ илгээчихдэг. Гааль, татварын мэдээллийнх нь системтэй холбогдчихож байгаа. Гаалийн бүрдүүлгийг цахимаар авчихна. Татварыг нь цахимаар төлчихнө. Ингээд эхлэхээр хэн ч, хүн тэнд байхгүй болоод эхлэхээр зөв явна.

Энэ болгоныг хийхэд зайлшгүй дижитал дэд бүтцээ сайжруулах хэрэгтэй байгаа.

Тэгэхээр кибер аюулгүй байдлын тогтолцоо, дижитал дэд бүтцээ сайжруулах чиглэлийн зорилт, хөтөлбөр, энэ арга хэмжээний төлөвлөгөөнд туссан гэдгийг бас хэлье.

**Э.Батшугар:** Ж.Чинбүрэн гишүүний микрофоныг нээе.

**Ж.Чинбүрэн:** Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе.

Би сая Сүхбаатарын талбай дээр жагсаж байгаа иргэдтэй гараад уулзаад эмч хүний хувьд бас биеийн байдал энэ тэрийг нь асуугаад эмнэлгийн тусламж, үйлчилгээ хэрхэн явж байгаа талаар гарч харлаа.

Иргэдээс гол ярьж байгаа зүйл бол энэ нээлттэй шилэн байх, иргэдийн боломжийг хулгайлахгүй байх, ямар нэгэн улс төрийн юм уу, эсвэл албан тушаалын давуу эрхээрээ далайлган боломжийг хулгайлахгүй байх л гэдэг асуудал яригдаж байгаа юм.

Тэгэхээр Н.Учрал сайдын сая ярьж байгаа зүйлтэй санал нэг байна. Ер нь бид энэ бирж байгуулж, энэ нүүрсний борлуулалт нь ил тод байдаг, түүнд хувийн хэвшлийнхэн нь өөрсдөө ямар нэгэн улс төрийн нөлөөлөлгүйгээр, эсвэл эрх дархтны дэмжлэггүйгээр энэ ажил нь өөрөө явдаг байх энэ тогтолцоог бий болгох ёстой.

Бид чинь өнгөрсөн хугацаанд том зүйлийг алдсан туршлага байгаа. Энэ бол эрүүл мэндийн цахим шилжилтийн асуудал. Мөн ялгаагүй Дэлхийн банкнаас 19 сая долларын төсөл яваад, тэгээд одоо бараг 7 сая доллар дээр гацаад түүнийгээ хийж чадахгүй. Одоо Дэлхийн банк буцаад татсан.

Инновац, цахим бодлогын байнгын хороо ирэх долоо хоногт энэ аудитын дүгнэлтийг бас хэлэлцэх байх гэж бодож байна.

Тэгэхээр эндээс сурсан зүйл юу байна вэ? Одоо энэ алдаа давтагдахгүй байх энэ өөрөө чухал. Бид их гоё тийм цахим, ил тод, нээлттэй, дижитал трансформэйшн хийх гээд байдаг. Үүнийгээ хийх зам маань өөрөө ямар нэгэн авлига юм уу, ашиг сонирхлын зөрчил орж ингээд хэрэгжиж чаддаггүй, саатдаг, гацдаг. Тэгээд мөнгөө бүрэн авч чадахгүй ийм алдаа бид туулсан. Туулаад байж байна.

Тэгэхээр ийм алдаанаас та бүхэн юу сурав? Энд хариулж өгөөч.

**Э.Батшугар:** Н.Учрал сайдын микрофоныг нээе.

**Н.Учрал:** Цахим эрүүл мэндийн төсөлтэй холбоотой олон гишүүд шүүмж хэлж байгаа.

Тэгээд Ж.Чинбүрэн гишүүн ч гэсэн өмнө нь бид энэ ажлын хэсэг дээр хамтарч ярилцаж очиж ажилласан. Намайг Байнгын хорооны дарга байхад бас ажлын хэсэг байгуулсан. Дээрээс нь ингээд Их Хурлаас Байнгын хороо тогтоол гаргасан.

Тэгээд би сайдаар томилогдоод Эрүүл мэндийн сайдтай хамтраад ажлын хэсэг байгуулсан. Ер нь юун дээрээ гацсан юм бэ. Аудит өөрөө, олон улсын тэр

байгууллага нь өөрөө дүгнэлт дээрээ муу гэж дүгнэсэн. Тэгээд юунаас болсон бэ гэдэг дээр эргэж харах ёстой гээд.

Өнгөрсөн хугацаанд ажлын хэсэг ажиллаад. Би бас мэргэжлийн холбоодын төлөөллийг оруулаад, ингээд мэргэжлийн холбоод нэгдсэн дүгнэлт гаргаад одоо цаашаа яаж явах вэ гэдэг саналаа маргааш танилцуулах гэж байгаа юм.

Тэгээд би тэр ажлын хэсэг дээрээ Ж.Чинбүрэн гишүүнийг, бас Байнгын хорооны даргыг урьж байна. Тэдний гаргасан шийдэл юу вэ гэдгийг би мэргэжлийн холбоодын саналыг сонсьё гэж шийдвэрлэсэн.

Өнгөрсөн хугацаанд нэг л дүгнэлтэд хүрсэн нь юу вэ гэхээр төсөл хэрэгжүүлдэг. Тэгээд төсөл хэрэгжүүлээд эхлэхээр яг мэргэжлийн худалдан авалт ерөөсөө хийж чаддаггүй. Хувийн хэвшилдээ янз бүрийн ажил зарладаг, тендер зарладаг. Юу хүсээд байгаагаа хэлж чаддаггүй. Тэгээд юу хүсээд байгааг нь хэлж чадахгүй байгаа учраас нөгөө хувийн байгууллага ч гэсэн одоо тэр тухайн шаардлагад нь нийцсэн бүтээгдэхүүнийг гаргаж өгч чаддаггүй. Ингээд хувийн хэвшил болоод тэр хоёрын хооронд дандаа үл ойлголцол үүсчихсэн.

Тийм учраас цаашдаа энэ **“Ухаалаг засаг-2 төсөл”** дээрээ бид илүү мэргэжлийн яамны зүгээс ажиллах ёстой. Одоо бид нарт яг юу хэрэгцээтэй байгаа юм бэ. Эрх ашгаа эрэмбэлээд зөв дараалалтайгаар ажиллах ёстой гэдэг утгаараа арга хэмжээний төлөвлөгөөн дээр ч гэсэн энэ **“Ухаалаг засаг-2 төсөл”** бол янз бүрийн программ хангамж худалдаад авах зориулагдахгүй.

Одоо энэ оны төсөв дээр манай яам нэг ч төгрөгийн программ хангамж худалдаж авна гэдэг төсөв оруулаагүй шүү дээ. Энэ төсөл бол илүү дижитал дэд бүтцийг хөгжүүлэх. Тэгээд бэхжүүлэх. Дээрээс нь дижитал ур чадвараа хөгжүүлэхэд чиглэгдэнэ.

**“Ухаалаг засаг-1 төсөл”** бараг 70 хувь нь дэд бүтцийг хөгжүүлэхэд л зарцуулсан юм билээ. Яг тэр тоног төхөөрөмжийг авах, тэр лиценз авах, аюулгүй байдлыг хангах чиглэл рүү.

Тэгээд бид Кибер аюулгүй байдлын хуулийг батлан гаргасан. Кибер аюулгүй байдлыг батлах хуулийг батлан гаргачхаад ямар нэгэн төсөв мөнгөгүйгээр бид кибер аюулгүй байдлын энэ тогтолцоогоо бэхжүүлнэ гэж угаасаа байхгүй. Одоо хуулийн дагуу гарах нийтдээ 37 журам байгаа. Энэ журмуудыг одоо ингээд гаргаад явж байна.

Засгийн газраар бараг энэ долоо хоногт байна уу, энэ киберийн аюулгүй байдалтай холбоотой журмуудыг батална. Ингээд ухаалаг засгийн хүрээнд кибер аюулгүй байдлын тогтолцоогоо бэхжүүлэхийн тулд нөгөө **public, national CERT** [Computer Emergency Response Team] хоёрыг байгуулах ажлыг бас суулгаж байгаа гэсэн үг.

Тэгэхээр ерөөсөө цаашдаа энэ “Ухаалаг засаг-2” дээр бидний хамтын ажиллагаа маш их чухал. Одоо бие даасан яамтай болсон.

Тэгэхээр энэ дээр яам болгоны, төрийн байгууллагууд болгоны тэр программ хангамж, худалдан авалтууд дээр мэргэжлийн яамны зүгээс зөвлөмж өгдөг, дүгнэлт гаргадаг ийм механизмыг өнгөрсөн хугацаанд бүрдүүлсэн гэж та бүхэн ойлгож болно.

Тэгээд энэ Эрүүл мэндийн яамны тэр цахим эрүүл мэнд дээр бас нэмэлт мэдээлэл ажлын хэсэг нь өгөх байх. Дээрээс нь “**Ухаалаг засаг-1**” бол дүгнэлт нь их сайн өгөгдсөн байхгүй юу. Цахим эрүүл мэндийг бодох юм бол энэ **Smart government I** төсөл бол амжилттай хэрэгжсэн. Одоо энэ “Үндэсний дата төв”-ийг бэхжүүлэх, тэр тоон гарын үсгийн асуудлуудыг гээд бүхэлд нь олон асуудлуудыг шийдвэрлэсэн.

Тэр “Ухаалаг засаглал-1”-ийн тухай, дээрээс нь тэр цахим эрүүл мэндтэй холбоотой асуудлаар ажлын хэсэг нэмэлт мэдээлэл өгөх үү.

**Э.Батшугар:** 4 номерын микрофоныг нэе.

**Ж.Тамир:** Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Мэдээллийн технологийн хэлтсийн дарга Ж.Тамир.

Ухаалаг засаг төсөл нь Дэлхийн банкны санхүүжилтээр 2015 онд батлагдаад хэрэгжиж эхэлсэн.

Ж.Чинбүрэн гишүүний хэлж байгаа “**Цахим эрүүл мэнд**” төсөлтэй яг адилхан нэг өдөр батлагдаж, ижил цэгээс гараагаа эхэлсэн ийм төсөл байгаа.

Тэгээд энэ төслийн хувьд 2018 оноос эхлээд Дэлхийн банкнаас хэрэгжилт дээр нь анхаарал хандуулах шаардлагатай гэж үзсэний үр дүнд манай Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас Төслийн удирдах хороогоо шинэчлэн байгуулж. Мөн түүнчлэн энэ төсөл хэрэгжүүлэх нэгжээ бас чадавхжуулсан байгаа. Тэгээд улмаар одоо 100 хувийн гүйцэтгэлтэй. Нийт төсвийн зарцуулалт нь болохоор 96.4 хувийн ийм төсвийн зарцуулалттайгаар дууссан.

Дэлхийн банкныхан амжилттай сайн хэрэгжсэн гэсэн ийм дүгнэлт гаргасан байна.

Төсөл амжилттай болох үндэс нь Н.Учрал сайдын хэлдэг үндэслэл мөн. Юу вэ гэхээр ажлын даалгавар боловсруулах техникийн үзүүлэлтээ гаргахдаа бүрэн гүйцэд гаргаж өгдөггүй.

Тэгэхээр түүнээс улбаалаад Дэлхийн банкныхан маань цаанаасаа бас зөвшөөрлөө өгөхгүй удчихдаг. Улмаар хугацаа алдаад тухайн техникийн үзүүлэлт нь хоцрогдох, цаашлаад үнэ нь бас өөрчлөгдөх, үйлдвэрлэхээ болих гэх мэтчилэн

одоо тийм саад бэрхшээлүүд бол гарч ирдэг. Манай мэдээллийн технологийн салбарын төслүүдийн хувьд.

Тэгэхээр үүн дээр болохоор одоо мэргэжлийн яам нь цаашдаа ажиллах болохоор асуудал бол гарахгүй байх гэж бодож байна. Түүнчлэн энэ манлайлал бас их чухал байдаг юм билээ. Энэ төслийн хувьд.

Тэгэхээр манай Хэрэг эрхлэх газрын удирдлагын зүгээс манлайллыг сайн авч хэрэгжүүлсний үр дүнд энэ төсөл маань амжилттай хэрэгжсэн. Цаашдаа Дэлхийн банкныхантайгаа сайн хамтарч нягтарч ойлголцож ажилласны үр дүнд энэ төсөл амжилттай болсон гэж үзэж байна.

Эрүүл мэндийн яаман дээр хэрэгжиж байгаа цахим эрүүл мэндийн төслийн хувьд миний хувьд сайн мэдээлэлгүй байна. Бусад ажлын хэсгийн гишүүдийн мэдээлэлтэй хуваалцах байх аа.

**Э.Батшугар:** Ж.Чинбүрэн гишүүн тодруулъя.

**Ж.Чинбүрэн:** Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал танд бас яг одоо гол цөм асуудал руу орж байгаад бас баяртай байна.

Ер нь эрүүл мэндийн цахим шилжилтийн том алдаа юу байсан гэхээр одоо бид нар дөрвөн замын уулзвар гээд аваад үзэх юм бол тэр зам байна, гэрлэн дохио байна. Зам, гэрлэн дохиогоо хийх ёстой болохоос тэр дээр явах машинуудыг худалдаж авах гээд байгаа байхгүй юу. Тэр ямар машин явах нь хэнд ямар хамаа байна. Тэр эрүүл мэндийн салбар байгууллагууд программаа өөрсдөө хангамжаа аваад. Харин тэр өгөгдлүүд нь тэр засмал зам дээрээ гэрлэн дохиогоороо жигд яваад, бүх мэдээллүүд нь нэг цэг дээр очиж төлбөр тооцоо нь хийгдэх, хүн мэдээллээ ч авдаг ийм л байх ёстой. Үүнийг цахим платформ гэж яриад байгаа шүү дээ, бид.

Тэгэхээр үүнийгээ хийж чадахгүй аваачаад тийм төрлийн машин авна гээд, эсвэл программ авна гээд буруу тодорхойлсноос болоод энэ эрүүл мэндийн салбарын цахим шилжилт өөрөө нурчихсан.

Тийм учраас үүнийг бас анхаарч байгаад баярлалаа. Тэгээд бид ирэх долоо хоногт энэ эрүүл мэндийн цахим шилжилттэй холбоотой асуудал бол.../минут дуусав/

**Э.Батшугар:** Ц.Сэргэлэн гишүүний микрофоныг.

**Ц.Сэргэлэн:** Би ганц нэг асуулт байна. Н.Учрал сайдаас ер нь асууя даа.

Гадаадын иргэдийн эрх зүйн байдлын тухай хууль батлагдаж, би ажлын эрхийг нь ахалж ажилласан хүн.

Тэгээд энэ хууль дээр нэг гол маш чухал асуудлыг шийдчихсэн байдаг юм. Энэ цахимтай холбоотой. Энэ юу вэ гэхээр цахим виз олголт. Монгол Улсын хилээр Монгол Улсад нэвтэрч байгаа гадаадын иргэдийг биометрийн өгөгдлөөр нь бүртгэж авах тухай асуудал.

Өнгөрсөн оны 06 сарын 01-нд энэ асуудал техникийн хувьд бүрэн хэрэгжээд ажил хэрэг болох байсан юм. Энэ хуулиараа тэгж тооцож, 06 сарын 01-нээс хууль хэрэгжинэ гэж зааж өгсөн.

Би ажлын шугамаар асуулт асууж, мэдээлэл авахад энэ программ хангамж одоо болтол бүрэн төгс хийгдээгүй явж байгаа ийм байдал сонсогдсон. Үүнийг та нэг анхааралдаа аваач. Энэ бол хуулийн хэрэгжилтийн асуудал, Монгол Улсын аюулгүй байдлын асуудал. Олон асуудал энэ дээр холбогдож яригдах учиртай юм. Энэ маш чухал программ, систем юм. Үүнийг та анхааралдаа аваач ээ гэдэг би зүгээр нэгдүгээрт хүсэлт хэлэх гэсэн юм.

Хоёрдугаарт, сая таны хариулт, яриан дунд ч явж байна. Энэ Монгол Улсын хилээр гарч байгаа нүүрсний хэмжээ ч гэдэг юм уу. Ганц нүүрс ч биш. Ерөөсөө бүх эдийн засгийн статистикууд үүнийг цахимжуулна гэж байгаа. Энэ маш зөв.

Би энэ дээр холбогдолтой нэг санал ч гэдэг юм уу юм хэлье. Юуны өмнө манайх одоо энэ Цахим хөгжил, харилцаа холбооны яамтай болчихлоо. Монгол Улсыг төлөөлж гадаад улс орнуудтай, тэр дундаа хөрш орнуудтайгаа өөрийн чиг үүргийн хүрээнд харилцаа холбоо тогтоох, олон улсын гэрээ, эрх зүйн актуудыг байгуулах асуудлууд нэн яаралтай хийгдэж байгаа гэж би ойлгож байгаа. Ялангуяа энд хөрш орнуудынхаа гаалийн байгууллагуудыг Монгол Улсын гаалийн байгууллагатай улсын хилээр нэвтрүүлж байгаа бараа, таваарын тоон үзүүлэлт, статистикуудыг цахим болгож, мэдээлэл харилцан солилцдог, олон нийтэд нээлттэй болгох энэ асуудлыг онцгой анхаараач ээ гэж хүсэх гэсэн юм.

Тэгэхээр юуны өмнө олон улсын эрх зүйн талаасаа заавал шийдэгдэж байж энэ асуудал техникийн талаасаа шийдэгдэх учиртай.

Тэгэхээр эрх зүйн талаасаа энэ асуудлаар Та бүхэн ажиллаж байгаа юу? Миний ойлгосноор одоо энэ нүүрсний хулгайн асуудал ид яригдаад янз бүрийн л мэдээллүүд явагдаж байна. Энэ дунд Монгол Улсын хилээр нэвтэрсэн гаалийн бүрдүүлэлт хийгээд гарсан нүүрсний тоо хэмжээ Бүгд Найрамдах Хятад Ард Улсын гаалийн байгууллагад бүртгэгдсэнтэй тулгаж үзэх гэхээр Хятадын талаасаа хүсэлт тавиад байна. Одоогоор өгөөгүй байна гээд. Хамгийн сүүлийн байдлаар Х.Нямбаатар сайдын мэдээлэл дунд Хятадын талаас прокурорын байгууллагын шугамаар асуудал тавиад бүтсэнгүй. Одоо тэгээд хоёр улсын хил хамгаалах байгууллагуудын хамтын ажиллагааны хүрээнд энэ асуудлыг тавьж байна гэж мэдээлэл өгч байна.

Үүнийг хэрвээ хоёр улсын чиг үүрэг нь ижил, танай чиг үүрэг, танай яамны чиг үүрэгтэй ижил бүхий яам хоорондын харилцан ажиллагааны хүрээнд олон

улсын гэрээ эрх зүйг нь баталгаажуулаад техникийн хувьд шийдчихвэл энэ асуудал асуугаад байх юм байхгүй шууд цахимаар асуудлыг ил тод ард түмэн ч хардаг, албаныхан ч хардаг, олон улс ч хардаг ийм л болох юм.

Энэ асуудал дээр таныг анхаарч байгаа юу гэж би асуух гэсэн юм. Гэрээ эрх зүйн тал дээр шүү.

Дараа нь энэ онц чухал мэдээллийн систем бүхий байгууллагуудын мэдээллийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд энэ төслийн тодорхой хувийг хангах юу зориулах уу гэсэн асуулт байна. Би яагаад үүнийг асууж байгаа вэ гэхээр онц чухал мэдээллийн.../минут дуусав/

**Э.Батшугар:** Ц.Сэргэлэн гишүүнд 1 минут.

**Ц.Сэргэлэн:** Тэгэхээр онц чухал мэдээллийн жагсаалт бүхий байгууллагуудын цахим системийн аюулгүй байдлыг хангах асуудал бол маш чухал шүү.

Хил хамгаалах ерөнхий газар дээр төв сервер нь байдаг. Төрийн 5 байгууллага холбогдсон. Улсын хилээр нэвтэрсэн зорчигч тээврийн хэрэгслийг бүртгэх бүртгэлийн систем бол онц чухал мэдээллийн жагсаалтад орсон ийм систем.

Саяын Кибер аюулгүй байдлын тухай хуулиараа өнгөрсөн онд. Үүнээс өмнө яаж байсан юм бэ гэхээр байгууллага өөрөө л чадан ядан энэ кибер аюулгүй байдлыг хангах бүх талын техникийн нөхцөлийг хангаж ажиллаж байсан.

Би нэг жишээ хэлье. Энэ системд халдсан оролдлого асар их байдаг юм шүү. Харамсалтай нь нэвтэрч чадаагүй. Хамгаалалтыг тухайн үед чадлаараа хийсэн учраас нэвтэрч чадаагүй. Ямар ч мэдээллийг авч чадаагүй, устгаж чадаагүй юм.

Тийм ч учраас нөөдөр энэ Монгол Улсын хилээр.../минут дуусав/

**Э.Батшугар:** Н.Учрал сайдын микрофоныг нээе.

**Н.Учрал:** Ц.Сэргэлэн гишүүн их чухал асуудлуудыг хөндлөө.

Нэгдүгээр асууж байгаа энэ Гадаадын иргэний эрх зүйн байдлын хууль, энэ цахим виз олголтын асуудлыг хуульчилж өгсөн. Тэгээд бид Их Хурлаас хамт баталсан.

Үүнтэй холбогдуулаад Хууль зүй, дотоод хэргийн яам энэ цахим визийг олгоод эхлээд одоо явж байгаа. Энэ системийг ч гэсэн нэг хувийн хэвшлээр хийж гүйцэтгүүлээд ингээд одоо ажил нь өрнөж байгаа. Цаашдаа цахим виз олгох



орнуудын тоог нэмэгдүүлэхээр нэлээд олон орнууд руу хүсэлт тавиад цахим визийн олгох орнууд нэмэгднэ.

Үүн дээр бид онцгой анхаарал тавина. Тэгээд манай Цахим хөгжил, харилцаа холбооны яам илүүтэй салбар дундын уялдааг хангах, технологи талаас нь мэргэжлийн яамны зүгээс зөвлөмж өгч хамтарч ажиллах ийм үүрэгтэй. Мэдээж манай яам бол технологийн талаас нь гэхээс биш энэ бол бас Хууль зүй, дотоод хэргийн яамны ажил. Бизнесийн энэ зөвшөөрлийг цахимжуулах бол Эдийн засгийн яамны ажил.

Тэгэхээр би өнгөрсөн хугацаанд гол баримталсан бодлого бол яам бүртээ яг энэ энэ чиглэлээрээ хамтарсан ажлын хэсгүүд байгуулаад хамтраад ажиллаад эхэлсэн. Жишээ нь, Эдийн засгийн яамтай яг энэ зөвшөөрлийг цахимжуулах дээр кодлох эрх нь тэр яаманд байдаг.

Хууль зүйн яамтай яг энэ чиглэлээрээ хамтарсан ажлын хэсгийг Х.Нямбаатар сайд бид хоёр байгуулсан.

Одоо тэр асуудал дээр хоёр асуудлыг хөндөж байгаа. Нэгд, энэ Гадаадын иргэний эрх зүйн байдлын хуулийн дагуу энэ цахим виз олголт. Дээрээс нөгөө e-passport, e-gate гээд ажлууд хийгдэж байгаа шүү дээ. Одоо e-gate бол Хууль зүйн яаман дээр худалдан авалт хийгдээд ирэх онд e-gate нэвтэрч эхэлнэ. Дээрээс нь e-pass-ийг нэвтрүүлэх ийм гурван ажил.

Ингээд одоо таны хэлсэн түрүүний тэр олон улсын гэрээтэй холбоотой ажил дээр зайлшгүй тэр боомтыг цахимжуулах, энэ автоматжуулах ажлыг ч гэсэн технологийн хувьд зөв интеграц хийж, хоорондоо мэдээлэл солилцох бололцоог нь хангахгүй бол яг ингээд л урд урдаасаа гацчих ийм магадлал үүсээд байгаа байхгүй юу.

Тийм учраас бид нар яг энэ эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр Хууль зүйн сайдтай хамтарсан энэ ажлын хэсгийн хүрээнд ажиллаж байгаа.

Тэгээд энэ холбогдох хуулиудад өөрчлөлт оруулна гэхээр олон салбарын асуудал. Бараг 170 гаруй хуулийг хөндөж таарч байгаа юм. Цахимжилтыг нэвтрүүлээд. Иргэдэд цахимжилт мэдрэгдэнэ гэвэл. Заавал цаасаар нэгтгэх асуудлуудыг шийдье. Энэ олон улсын гэрээтэй холбоотой асуудлуудыг шийдье. Дээрээс нь банк, санхүүгийн салбарт танин баталгаажуулах, харилцагчаа таньж мэдэх ажлууд гээд олон ажил хийгдэх учраас 170 хуулийг хөндөхөөр. Дүрэм, журмын түгжээнээс гаргах энэ хуулийг энэ чуулганаар одоо манай хоёр яамнаас хамтарч ажиллаж байгаа ажлын хэсэг Их Хуралд өргөн барина гэдгийг хэлмээр байна.

Гуравт, онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллагуудын жагсаалтыг Засгийн газраас баталсан. Энэ онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллагуудын жагсаалтад орсон байгууллагуудын аюулгүй байдлыг хуулиараа

тагнуулын байгууллагын дэргэдэх **National CERT** /Computer Emergency Response Team/ төв байгуулж ажиллах ёстой.

Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын албатай бас хамтарсан ажлын хэсэг байгуулсан. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын алба. Энд кибер цэргийн командлал. Дээрээс нь онц чухал мэдээллийн дэд бүтцийг хариуцаж байгаа **National CERT** төв.

Манайх бол нөгөө хувийн иргэдийн аюулгүй байдлыг хангах **Public CERT** гээд энэ гурван төвүүд нэгдэж байж ажиллах байдлаар энэ CERT төвүүдийгээ байгуулах гэж байгаа.

Одоо төсөв мөнгө байгаагүй. Гэхдээ өнгөрсөн хугацаанд Тагнуулын дэргэдэх кибер аюулгүй байдлын газар, манай Үндэсний дата төвийн дэргэдэх Кибер аюулгүй байдлын хэлтэс, Кибер цэргийн командлал гээд.

Ингээд бүхэлдээ тоног төхөөрөмж, дэд бүтцийг шийдүүлэх чиглэлээр энэ арга хэмжээний төлөвлөгөөний 2.3 дээр кибер аюулгүй ажиллагааны тогтолцоог сайжруулах, дэд бүтцийг бий болгох.../минут дуусав/

**Э.Батшугар:** Надад асуух хэд хэдэн асуулт байна. “Ухаалаг засаг-1 төсөл”-ийг 2015 оноос 2022 оны хооронд хэрэгжсэн.

Тус төслийн хүрээнд харилцаа холбооны дэд бүтэц, инновац үйлдвэрлэл, нээлттэй өгөгдлийг хөгжүүлэх, төрийн цахим үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх талаар ажлууд хийгдсэн.

Тэгэхээр та бүхний дүгнэлтээр энэ “Ухаалаг засаг-1 төсөл” хэдэн хувийн амжилттай хэрэгжсэн гэж бодож байна. Эхний асуулт.

Хоёрт, “**Ухаалаг засаг-2 төсөл**”-ийн хүрээнд хийгдэж ажил, хүлээгдэж буй үр дүн гэсэн зарим хэсэгт үйл ажиллагаа нь өнөөдрийн байдлаар хийгдсэн ажил бол байна.

Тэгэхээр хийгдсэн байгаа ажлуудын зарим хэсгийг нь өөрчлөх нь зүйтэй гэж бодож байна. Тэгэхээр энэ өөрчлөх боломж байгаа юу? Ялангуяа кибер аюулгүй байдлын тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан кибер халдлага, зөрчилтэй тэмцэх үндэсний төв болон нийтийн төвийн үйл ажиллагаанд зарцуулах боломжтой юу гэж асуумаар байна.

4 номерын микрофоныг нээе.

**Ж.Тамир:** Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Мэдээллийн технологийн хэлтсийн дарга Ж.Тамир.

“Ухаалаг засаг-1 төсөл”-ийн хэрэгжилтийг Дэлхийн банкныхан үнэлдэг. Үнэлэхдээ 2016, 2017, 2018 онуудад дунд, хангалтгүй гэсэн үнэлгээ өгөөд, 2020 оноос эхлээд дунд, хангалттай, 2021 оноос эхлээд хангалттай гэсэн үнэлгээг өгсөн байна.

Тэгэхээр энэ төсөл маань хангалттай гэсэн үнэлгээгээр нэгдүгээрт Дэлхийн банкныханд үнэлэгдсэн байдаг.

Хоёрдугаарт, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын үнэлгээгээр 2017 онд 32 хувь, 2018 онд 39 хувь. Тэгээд 2019 онд 65.5 хувь гэж явсаар байгаад 2022 онд төсөл дуусахдаа 100 хувийн үнэлгээтэй үр дүнтэй гэсэн ийм үнэлгээ гарсан байдаг юм байна.

“Ухаалаг засаг-2 төсөл”-ийн хувьд зарим үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг өөр хооронд гүйлгэх боломжтой эсэх талаар манай ажлын хэсгийнхэн нэмэлт тайлбар өгөх байх.

**Э.Батшугар:** 7 номерын микрофоныг нэе. Сангийн яам.

**Б.Одонтуяа:** Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга Б.Одонтуяа. Гишүүний асуултад хариулъя.

Тэгэхээр одоо Олон улсын гэрээний тухай хуулийн дагуу энэхүү төсөл Их Хурлаар дахиж орж батлагдах нөхцөлтэй байгаа. Дэлхийн банкны зүгээс төсөл дотроо **redesign**, бас **component** хооронд гүйлгэх энэ асуудлыг Монгол Улсын зүгээс яг олон улсын гэрээ болгож зээлийн гэрээг соёрхон баталсны дараа Монгол Улс энэхүү зээл дээр committed гэсэн буюу амлалт, үүрэг хүлээнэ.

Үүний дараа зээлийн энэ төсөл хооронд гүйлгэх асуудлыг дахиж авч хэлэлцэж болно гэж мэдэгдсэн байгаа.

**Э.Батшугар:** Зээлийн хэлэлцээрийн төсөлтэй холбогдуулан гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. /алх цохив/

Зээлийн хэлэлцээрийн төсөлтэй холбогдуулан үг хэлэх гишүүд нэрээ өгнө үү. Байхгүй байна. Тийм ээ.

Ер нь миний бие бас хэдэн үг хэлье. Сая сүүлийн гурван сард 40 гаруй төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудтай уулзсан. Тэгээд уг уулзалтын үр дүнд манай мэдээлэл технологийн салбар дээр тулгамдаж байгаа асуудлаас гурван асуулт ерөнхийдөө дийлэнхдээ яригдаж байгаа юм.

Эхнийх нь хүний нөөцийн асуудал. Хоёрт нь, салбар хоорондын интеграци болон төрийн байгууллага хоорондын системийн интеграцийн асуудал яригдаж байгаа юм. Гуравт нь, кибер аюулгүй байдлын талаар яалт ч үгүй яригдаж байгаа асуудал.

Түрүүн бас хэлж байна. Манай улс эрэмбээрээ 180 улс орноос 120-д орж байгаа. Энэ бол бас тодорхой хэмжээнд яагаад ч сайн бахархаад байх зүйл биш.

Тэгэхээр та бүхэн санаж байгаа бол Улсын Их Хурлын Инновац, цахим бодлогын байнгын хороо 10 сард хуралдаад Засгийн газарт чиглэл өгөх тухай тогтоол баталсан. Тус тогтоолд энэ кибер халдлага, зөрчлийг илрүүлэх, таслах зогсоох, хариу арга хэмжээ авах, кибер зөрчилд өртсөн мэдээллийн системийг сэргээх, дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төв. Мөн Үндэсний төвийн санхүүжилтийг шийдвэрлэх талаар тогтоолд дурдсан байгаа.

Тэгэхээр энэ заалттай холбогдуулан тодорхой санхүүжилтийг “Ухаалаг засаг төсөл”-өөс зайлшгүй **National CERT**, Үндэсний төв болон Нийтийн төвийг байгуулахад зарцуулах нь зүйтэй гэж хэлмээр байна.

Та санаж байгаа бол бас Улсын Их Хурлын 11 дүгээр сарын 11-ний өдрийн 69 дүгээр тогтоолоор Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрыг байгуулж, энэ байгууллага 2023 оны үйл ажиллагаа явуулж эхэлнэ.

Тэгэхээр энэ агентлаг үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардлагатай тоног төхөөрөмж болон бусад бэлэн байдлыг хангах нэн шаардлагатай байна. Ялангуяа орон нутагт төрийн үйлчилгээг иргэдэд цахимаар хүргүүлэх, бэлэн байдлаа хангах нь хэрэгтэй шүү гэж онцолж хэлмээр байна.

Мөн Монгол Улсын иргэн бүр төрийн үйлчилгээг газар зүйн байдлаас үл хамаарч авах нь Монгол Улс жинхэнээсээ “**цахим үндэстэн**” болох гэсэн зорилгодоо хүрнэ гэдгийг бас дурдаж хэлье.

Зээлийн хэлэлцээртэй холбогдуулан гишүүд үг хэлж дууслаа. /алх цохив/

Санал хураалт явуулъя. Монгол Улс Дэлхийн банкны Олон улсын хөгжлийн ассоциаци хоорондын “Ухаалаг засаг-2 төсөл”-ийн зээлийн хэлэлцээрийн төслийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Ирц бэлэн үү. Санал хураалт.

Санал хураалтыг танилцуулъя. 9 гишүүн оролцож, 7 гишүүн дэмжлээ.

Монгол Улс, Дэлхийн банкны Олон улсын хөгжлийн ассоциаци хоорондын “Ухаалаг засаг-2 төсөл”-ийн Зээлийн хэлэлцээрийн төслийг хэлэлцэж дууслаа.

Монгол Улс, Дэлхийн банкны Олон улсын хөгжлийн асоциаци хоорондын “Ухаалаг засаг-2 төсөл”-ийн Зээлийн хэлэлцээрийн төслийг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Ц.Сэргэлэн танилцуулна.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдааныг хаасныг мэдэгдье. Хуралдаандаа идэвхтэй оролцсон гишүүд ажлын хэсэгт баярлалаа.

**Бичлэгээс буулгасан:**  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ  
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД